



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/548

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын хүрээнд Булган сумын нийтийн эзэмшлийн талбайн зэрлэг өвс, шарилж хадах цахилгаан хадуур, төв цэнгэлдэх хүрээлэнгийн наадмын талбайн хашааны зос хийх ажлын гүйцэтгэчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, 2,950,000 (хоёр сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2. Дээрх зардлыг Булган аймаг, Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0304010764